



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 420

Улаанбаатар хот

Г “Жонон даатгал” ХХК-д дүрмийн сангийн 7 хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жонон даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг нийт 500 000 000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчдийн нэрс	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт, нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Ганбямба овогтой Билгүүн	525 993 800.0	-	0.0	0,0%
2	Ганбямба овогтой Дөлгөөн	-	525 993 800.0	525 993 800.0	51,0%
3	Амар овогтой Мөнхнаст	-	500 000 000.0	500 000 000.0	49,0%
	Нийт	525 993 800.0	1 025 993 800.0	1 025 993 800.0	100,0%

2. Дүрмийн сангийн хэмжээ болон хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2011 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жонон даатгал” ХХК /Ш.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН